



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/СЭ

Улаанбаатар хот

Аян зохион байгуулах тухай


Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 15/06 дугаар тогтоолоор батлагдсан “Худалдаа, Хоол үйлдвэрлэл үйлчилгээ- 2020” нийслэлийн дэд хөтөлбөрийн 2.2.5, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх” журмын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Сайдын баталсан “Сав баглаа боодол үндэсний хөтөлбөрийг 2019 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэд төлөвлөгөө”-ний 9 дэх заалтыг дагуу хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах аяныг 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаатайгаар нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар ханган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс /Б.Эрдэнэчимэг/-т үүрэг болгосугай.

2. Дүүрэг бүрт зохион байгуулах аяны удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

3. Аяны арга хэмжээг хавсралтад заасан удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, тайланг фото зураг, судалгаагаар баталгаажуулан тогтоосон хугацаанд ирүүлэхийг дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Аяны хүрээнд хийгдсэн ажлын үр дүнг нэгтгэн, 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор танилцуулахыг Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс /Б.Эрдэнэчимэг/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны... сарын... өдрийн
... тушаалын хавсралт



**“ХҮНСНИЙ ЗОРИУЛАЛТЫН БУС ХУВАНЦАР САВНЫ
ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ АЯН”-Ы НЭГДСЭН УДИРДАМЖ**

Үндэслэл:

Сүүлийн үед Монгол улсад “цэнхэр, шар” гэх тодотголтой химийн бодис хадгалах, зөөвөрлөх зориулалт бүхий хуванцар савыг өдөр тутмын амьдралд хэрэглэж байгаа нь хүний эрүүл мэндэд хортой болох талаар ДЭМБ, Хордлого судлал, эрдэм шинжилгээний нийгэмлэгээс ихээхэн анхаарал хандуулж, тандан судалгааг хийсээр байна.

Манай улсад зориулалтын бус хуванцар сав болох цэнхэр сав, тосны канистер олдоц ихтэй, үнэ хямд байдгаас Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүд ундны ус, сүү, айраг зэрэг хүнсний шингэн бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэхэд өргөнөөр хэрэглэж байна.

Хөх савыг бат бөх болгох, халуун, хүйтэнд тэсвэртэй болгох, гаднын хүчтэй цохилт, доргилтод тэсвэрлэх чанарыг дээшлүүлэх зорилгоор түүхий эдийн найрлагад нь хар тугалга, формальдегид, аммиак, зэс, төмөр зэрэг хүнд металл агуулагддаг тул чихрийн шижин, үргүйдэл, арьс болон мэдрэлийн согог, хорт хавдар гээд олон төрлийн өвчний үүсгэвэр болдог гэдгийг мэргэжлийн эрдэмтэн, судлаачид хэлж, анхааруулж байна.

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс хийсэн судалгаагаар хуванцар саванд хадгалсан усан дахь хар тугалгын шилжилтийн хэмжээ ДЭМБ-ын зөвлөмж хэмжээ болон Монгол Улсад мөрдөж байгаа стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 60-800, формальдегид 1800-6900 дахин их байгааг тус тус тогтоосон байна.

Мөн хуванцар саванд хонуулсан усанд хийсэн шинжилгээний дүнг төвлөрсөн сүлжээний устай харьцуулахад төмөр 2 дахин, нитрит 11 дахин, аммиак 48 дахин их, сүүнд хүнд металл болох кадьюми стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс 3-4 дахин, айрагд 4.4 дахин их гарчээ.

Зорилго:

Хэрэглэгчдийн хэрэглээний зөв дадлыг төлөвшүүлэх, иргэдийн хүнсний зориулалтын бус хуванцар савны талаарх мэдлэгийг дээшлүүлэх, цэнхэр сав, тосны канистерын хэрэглээг бууруулах, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөр,

“Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ-2020” нийслэлийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад оршино.

Хамрах хүрээ:

Нийслэлийн 9 дүүрэг

Хугацаа:

2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаанд зохион байгуулна.

Зохион байгуулалт:

Аяныг Дүүргийн Засаг даргын орлогч ахлан Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Баянзүрх дүүргийн Статистикийн хэлтэс, хороодын Засаг даргын ажлын албатай хамтран зохион байгуулна.

Аяны хүрээнд хийгдэх ажил:

- Аяны хүрээнд дүүрэг бүр ажлын хэсэг байгуулж, нэгдсэн төлөвлөгөө гаргах;
- Хяналтын тооллого зохион байгуулж, хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээний өнөөгийн байдал, статистик суурь судалгаа гаргах;
- Төрийн бус байгууллагууд, холбоо нөхөрлөл, сайн дурын байгууллагуудтай хамтран ажиллаж, иргэдэд чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах;
- Химийн хорт бодисын хөх сав, тосны шар канистерын талаар иргэдэд зөвлөмж, гарын авлага тараах;
- Аяны хүрээнд хийгдэж буй ажлуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр өргөн хүрээтэй сурталчлах;
- Гүйцэтгэлийн хяналт зохион байгуулж, химийн хорт бодисын хөх сав, тосны шар канистерын суурь судалгаатай харьцуулан хэрэглээний бууралтыг тодорхойлох;

Үр дүнг тайлагнах:

Аяны хүрээнд зохион байгуулсан ажлын талаарх дэлгэрэнгүй тайланг 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэст ирүүлнэ.

---ooOoo---